

БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.БАЯРСАЙХАН

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

Дугаар:

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Засаг Даргын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/975 дүгээр захирамж - Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч П.Ганзориг 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 04/253 дугаартай албан бичиг
2. Байршил	Орон сууцны хороолол доторх зам засвар, тохижилтын ажил /ХУД/
3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө
4. Авто замын техникийн ангилал, замын зэрэг	Орон сууцны хороолол доторх зам, замын байгууламж
5. Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6. Замын хучилтын хийц	Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ
7. Зураг төсөл зохиох үе шат	1 үе шаттай 2024
8. Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага
9. Захиалагч байгууллага	Хан Уул дүүргийн Засаг Даргын тамгын газар
10. Зураг төслийн иж бүрдэл	1. Инженер геодезийн ажлын тайлан 2. Зам, замын байгууламжийн техникийн зураг 3. Тайлбар бичиг /ажлын нэр, тоо хэмжээ, зураг төслийн иж бүрдэл, холбогдох захирамж, тогтоол гэх мэт/ 4. Техникийн шаардлага 5. Ажлын төсөв /Магадлалаар оруулах/
11. Онцгой нөхцөл:	➤ Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн норм " БД31.101.04, "Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009, "Явган хүний зам, талбай төсөллөлт, техникийн шаардлага" MNS 6808:2019, "Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Барилга

байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, магадлал хийж, дүгнэлт гаргах журам” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх


- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/456 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх стандарт, шаардлага” USC 0901B:2020, USC 0902B:2020, USC 0903B:2020, USC 0001-01:2019, USC 0002-01:2019, USC 1901B:2020, USC 1403C:2020, USC 1404C:2020-ыг тус тус мөрдөх.
- НЗХГ-ын Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах техникийн даалгаврын дагуу зураг төслийг боловсруулах
- “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах
- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлыг өндрийн хэмжилтийн UTM системд хийн тайланг батлуулан хүлээлгэн өгөх. Геодезийн хяналтын инженерээр байрзүйн зураглалын зураг төслийг төлөвлөлтийн шатанд хянуулж баталгаажуулах
- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар хотын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан зураг төслийг боловсруулах
- Авто зам, замын байгууламжийн үндсэн элементүүд болох зорчих хэсэг, хайс, хашлага, гадаргуугийн ус зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан техникийн зургийг иж бүрнээр төлөвлөх
- Хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглолыг оновчтой төлөвлөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх
- Авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн шатанд Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн газар зохион байгуулалтын албатай санал солилцож зөвшилцөх
- Шаардлагатай тохиолдолд гэрэлтүүлгийг төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь “УБЦТС” ТӨХК-рүү бие даан хандаж техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийн боловсруулах.
- Авто зам, замын байгууламжийн трассд орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлуулах бол тусгах
- Техникийн зураг төсөлд байгуулалт, зай хэмжээ, дагуу огтлол, хөндлөн огтлол, хөдөлгөөн зохион байгуулалт, орц, гарцыг төлөвлөж цэгүүдийн координат, Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын тоо хэмжээг оруулсан байх
- Авто зам, замын байгууламжийн холбогдох норм дүрэмд нийцүүлэн тэмдэг тэмдэглэгээ, тоноглол тохижилтын хамт төлөвлөх
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

Дэвсгэр зураг	1:500
Дагуу огтлол	хэвтээ 1:1000 босоо 1:100
Хөндлөн огтлол	1:100
Уулзвар, огтлолцол	1:500
Бүтэц	1:20

- Авто зам, замын байгууламжийн техникийн зураг, тайлбар бичиг, инженер геодезийн хэмжилтийн тайлан, техникийн шаардлага, шаардлагатай тохиолдолд инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ архивд, орон зайн болон орон зайн бус мэдээллийг тоон хэлбэрээр мэдээллийн санд батлагдсан загварын дагуу хүлээлгэж өгөх.


Хянасан:

НЗХГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
дарга

 /В.Мягмар/

Боловсруулсан:

НЗХГ-ын Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
мэргэжилтэн

 /И.Номингэрэл/

2024 оны.....сарын.....-ны өдөр

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗАР

Газрын байршил

Хан Уул дүүрэг дүүрэг 1 дүгээр хороо

Газрын зориулалт
Авто зам, замын
байгууламж



Хянасан:
НЗХГ-ын БТХ-ийн дарга
Боловруулсан:
НЗХГ-ын БТХ-ийн мэргэжилтэн

ТАНИХ ТЭМДЭГ

Телевэллтийн хүрээ

Б.М.М.М. / В Мягмар /
И.Н.Н.Н. / И Номингэрэл /